

УУЛ УУРХАЙН САЛБАР

Уул уурхайн салбар 2024

ДНБ-д эзлэх хувь	27.3%
Экспортод эзлэх хувь	94%
Аж үйлдвэрийн салбар	72%
Гадаадын шууд ХӨО	79%
Биржийн арилжаа	₮8.2 их наяд
Улсын төсвийн орлогын	30%

ДНБ-д эзлэх уул уурхайн олборлолт



АМГТГ-ын улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлого /тэрбум ₮/



Нүүрсний дэлхийн зах зээлийн дундаж үнэ, ам доллар/тонн/



Монгол Улсын уул уурхайн салбар тогтвортой өсөлттэй хэвээр байж, эдийн засагт голлох байр сууриа хадгалсаар байна.

Монгол улсын ДНБ 2024 оны байдлаар 79.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 4.9 хувь өссөн. ДНБ-ийн өсөлт ихэнх олон улсын болон дотоодын шинжээчдийн төсөөллөөс доогуур гарсан бөгөөд үүний нэг шалтгаан нь Монгол улсын уул уурхайн гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн бууралт юм.

Монгол улсын уул уурхайн салбар ДНБ-ий 27.3%, улсын нэгдсэн төсвийн орлогын 30 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг эдийн засгийн тулгуур салбар бөгөөд тус салбарын тогтвортой байдал нь манай эдийн засгийн тогтвортой байдалтай шууд хамааралтай байдаг. 2021 он буюу цар тахлын нөхцөл байдлаас хойш ДНБ-д эзлэх уул уурхайн олборлолтын хувь хэмжээ 2.6% хувиар нэмэгдсэн боловч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар буурсан.

АМГТГ-ын Улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлого 2024 онд 322.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь 2021 онтой харьцуулахад 53.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй боловч өмнөх мөн үетэй харьцуулахад 79.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. 2024 онд АМГТГ-аас 355.9 тэрбум төгрөг улсын төсөвт татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан бол 33.7 тэрбум төгрөгөөр дутуу жилийн эцэс гарсан байна.

Экспортод борлуулагдсан нийт аж үйлдвэрийн салбар 2024 онд 36.2 их наяд төгрөгийн борлуулалт хийсний 34.9 их наяд нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт бүрдүүлсэн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 60.0 хувийг нүүрс олборлолт, 35.6 хувийг металлын хүдэр олборлолт, 3.1 хувийг газрын тос олборлолт, 1.3 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Тусгай зөвшөөрлийн тоо




Нийт нутагт дэвсгэрт эзлэх, %



Тусгай зөвшөөрлийн ХЕО статистик



Гадаадын 100% хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН тоо



Тусгай зөвшөөрөл

Монгол улсын уул уурхайн салбарын тусгай зөвшөөрлийн тоо тогтмол өссөөр байгаа бөгөөд 2021 онд (2636) байсан бол 2024 онд (2740) болж 104-өөр нэмэгдсэн статистик үзүүлэлттэй байна. Уг өсөлтийн шалтгаан нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа өргөжиж, салбарын бодлого сайжирсантай шууд холбоотой юм.


Нийт нутаг дэвсгэрт эзлэх ашигт малтмалын талбай 2021 онд 3.9% байсан бол 2024 онд 4.4% болж тэлсэн үзүүлэлттэй байна. Нийт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ 2024 онд 6,997.5 мянган га газар бүртгэгдсэн байна. Энэ нь 2021 оноос хойш 750 мянган га газраар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Уул уурхайн салбарт нийт 2740 тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд үүнээс 1761 нь эзэмшигчтэй, үлдсэн 979 нь эзэмшигчгүй буюу ашиглалтанд ороогүй байна. Дотоодын аж ахуйн нэгжүүд 394 тусгай зөвшөөрөлтэй үүнээс 251 нь идэвхтэй ашиглагдаж байгаа нь дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд уул уурхайн салбарт харьцангуй бага оролцоотой байна.


Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүд нийт тусгай зөвшөөрлийн 80.2%-ийг эзэмшиж байна. Энэ нь Монгол улсын ашигт малтмалын нөөцийн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо өндөр байгааг харуулж байна.

Монгол улсад Гадаадын хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдээс Хятад улс 50.25% буюу талаас илүү хувийг дангаараа бүрдүүлж байна. Виржиний Арлууд 10.41%, Хонг-Конг 9.14%, Сингапур 7.87%, Бусад улсууд 22.34% бүрдүүлсэн статистик үзүүлэлттэй байна.

Уул уурхайн экспортын бүтэц




Экспортод гарсан нүүрсний статистик



Экспортод гарсан зэсийн баяжмал



Алтны статистик




Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь эдийн засгийн голлох хөдөлгөгч хүчин зүйлийн нэг бөгөөд 2024 оны байдлаар нийт экспортын 54.1%-ийн чулуун нүүрс, 21%-ийг зэсийн баяжмал, 5.7%-ийг алт, 3.8-ийг төмрийн хүдэр, 15.4%-ийг бусад бүтээгдэхүүн эзэлж байна.

Чулуун нүүрс (54.1%): Чулуун нүүрс нь экспортын хамгийн өндөр хувийг бүрдүүлж буй бүтээгдэхүүн бөгөөд 2021-2024 оны хооронд нүүрсний экспортын хэмжээ 67.7 сая тонноор өссөн бөгөөд үүний зэрэгцээ экспортын орлого 5.9 тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна. 2024 онд Монгол улс 83.8 сая.тн нүүрс экспортод гаргасан нь түүхэн дээд үзүүлэлт юм.

Зэсийн баяжмал (21%): Зэсийн баяжмалын экспортын хэмжээ тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2021 онд 1.3 сая тонн байсан бол 2024 онд 1.7 сая тонн болж, 30.7% -иар үзүүлэлттэй байна. Экспортын орлого 2024 онд 3.3 тэрбум ам.доллар-т хүрсэн нь өмнөх оныхоос 0.7 тэрбум ам.доллар өссөн үзүүлэлт юм. Энэ нь дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өссөнтэй холбоотой бөгөөд 2023 оны 12-р сард тонн зэсийн үнэ 8,173.5 ам доллар байсан бол 2024 оны 12 сард 8,919.2 ам.доллар болж 9.1%-иар өссөн байна. Монгол Улсын зэсийн томоохон орд болох “Эрдэнэт үйлдвэр” жилд дунджаар 569 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэдэг бол “Оюу-толгой” ХХК 2028-2036 онуудад жилд дунджаар 500,000 тонн зэс олборлох зорилт тавин ажиллаж байна.

Алт (5.7%): Алтны экспорт хэмжээ тогтвортой өсөлттэй байсан бөгөөд 2021 онд 1.3 тонн байсан бол 2024 онд 1.7 тонн болж 30.77% өсөлттэй байсан байна. Мөн нийт үнийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 161.4 сая ам.доллараар нэмэгдэж 21.87%-иар өссөн байна. Өсөлтийн гол шалтгаан олон улсын зах зээл дээр алтны ханш өссөнтэй холбоотой бөгөөд 2023 оны 12 сард алтны ханш 2,029.3 ам.доллар байсан бол 2024 оны 12 сард 2,644.1 болж 30.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Дэлхийн ураны нөөц




Зөөвч-Овоо (нөөцийн мэдээлэл)



Дэлхийн ховор элементийн статистик



Нийт зургаан ордны нөөц



САЛБАРЫН ИРЭЭДҮЙН ХӨГЖИЛ

УРАН

Дэлхийн ураны нөөцийн 54 хувийг Австрали, Казахстан, Канад улсууд эзэмшиж байна. Монгол улс 141,500 тонн ураны нөөцтэйгээр дэлхийд 10 дугаарт бичигдэж, нийт дэлхийн ураны нөөцийн 2 хувийг эзэлж байна. Зөөвч-Овоо ураны орд Монгол Улсын Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрладаг бөгөөд сүүлийн 20 жилд дэлхийн илрүүлсэн хамгийн том 10 ураны ордны нэгэнд тооцогдож байна. Монгол Улсын Засгийн газар, Францын "Орано Майнинг С.А.С" Компани хамтран, ураны "Зөөвч-Овоо" төслийг эхлүүлэх хөрөнгө оруулалтын гэрээг /2025.01.17/ байгуулсан. Зөөвч-Овоо төслийн хүрээнд Монгол улс нийт 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттайгаар 30 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд жилд 2,500 тонн уран олборлохоор төлөвлөсөн байна. Нийт борлуулалтын орлого 14 тэрбум ам.долларт хүрэх бол Монгол талын цэвэр ашиг 5.1 тэрбум ам.доллар байх бөгөөд орон нутагт 1.3 тэрбум ам.доллар татвар, төлбөр төлөхөөр тооцоолж байна.

ГАЗРЫН ХОВОР

Монгол улс нийт 3.1 сая тонн газрын ховор элементийн нөөцтэйгээр дэлхийд эхний 10-т багтаж байна. Газрын ховор элемент нь төрөл, цэвэршилт, зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамааран нэг грамм элементүүдийн үнэ 10-20,000 ам.доллар хүрдэг. Монгол улсад технологи, боловсон хүчин дутмаг байдлаас хамаарч нэмүү өртөг шингээлгүй нэг тонныг нь 4,000 ам.доллаароор экспортлодог.

Халзанбүрэгтэйн болон Хотгорын ордууд хамгийн их нөөцтэй бөгөөд эдийн засгийн эргэлтэд оруулах гол ордууд юм. Нийт 3.1 сая.тн газрын ховор элемент нь дэлхийн зах зээл дээр ойролцоогоор 10 тэрбум ам.доллар-ын үнэлгээтэй бөгөөд ГХЭ-ийг боловсруулж нэмүү өртөг шингээж экспортолсноор жилд 2.1 тэрбум ам.доллар олох боломжтой юм.